

Улсын бүртгэлийн
дугаар

Нууцын зэрэглэл:

Аравтын бүрэн
Ангиллын код

Төсөл гүйцэтгэх гэрээний
дугаар: Шу/х/ОХУ/-2019/14

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
НЭЭЛТТЭЙ БОЛОВСРОЛ ТӨВ

МОНГОЛ БОЛОН ЗҮҮН СИБИРИЙН ТОМООХОН НУУР, УСАН САН ОРЧМЫН ЦАГ УУРЫН БЭСРЭГ ХЭМЖЭЭСИЙН ПРОЦЕССИЙН СУДАЛГАА

Шинжлэх ухаан, технологийн төслийн тайлан
2020-2022

- Төслийн удирдагч:** Д.Ганбат – доктор (Ph.D), профессор
- Төслийн гүйцэтгэгч:** Г.Гантуяа – доктор (Ph.D), дэд профессор
С.Энхжаргал – докторант
Д.Одонтунгалаг – магистр
Н.Буянбилиг – магистрант
- Санхүүжүүлэгч байгууллага:** БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн сан
- Захиалагч байгууллага:** БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлогын газар
- Гүйцэтгэгч байгууллага:** Шинжлэх ухаан, технологийн их сургууль
14191 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу.
Утас: +976-9914-7004
Цахим хаяг: ganbatda@must.edu.mn
<http://www.must.edu.mn>

Хураангуй

Далай, тэнгисээс алслагдсан, өндөрлөг газарт орших Монгол орон болон Зүүн Сибирийн томоохон нуурууд нь бэсрэг хэмжээсийн болон орон нутгийн уур амьсгалыг бүрэлдүүлэгч чухал системийн нэг байдаг. Хиймэл дагуулын мэдээг боловсруулж харахад зуны улиралд хур тунадасны хэмжээ Байгаль нуурын мандал дээр эргэн тойрноосоо бага ордог байна. Энэхүү бууралт нь нуураас үүдэлтэй агаар мандлын өөрчлөлтөөс үүдэлтэй эсэхийг судлахын тулд 2005-2019 оны 15 жилийн хугацаанд тоон загварчлалын симуляци гүйцэтгэв. Бүс нутгийн уур амьсгалын хоёр симуляцийг нэг нь нуурыг ойгоор орлуулж хийсэн. Симуляцаас харахад нуур нь зуны улиралд орох хур тунадасны хэмжээг 13%-иар бууруулдаг нь харагдав. Нуур нь өдрийн цагаар гадаргын ойролцоох агаарын температурыг бууруулж, нуурын дээгүүр агаар мандлын илүү тогтвортой нөхцөлийг бий болгодог. Суларсан конвекцийн хамт дулааны далд урсгал багасч, нуурын дээгүүр чийг буурдаг. Нуурын нөлөөгөөр тунадасжих усны хэмжээ багасч, конденсаци нь доош чиглэсэн богино долгионы цацрагийг ихэсгэдэг бөгөөд энэ нь нуур дээрх конвекцийн сулралыг хэсэгчлэн нөхөх чадвартай. Төслийн тавьсан зорилтын хүрээнд судалгааг гүйцэтгэлээ.

Тайлан өмчлөгч: Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Нээлттэй боловсрол төв

Түлхүүр үгс: тоон загварчлал, симуляци, бэсрэг процесс, агаар мандал нуурын харилцан үйлчлэл, нуур.

Гарчиг

Хураангуй.....	1
Түлхүүр үгс	2
I Бүлэг Сэдвийн судлагдсан байдал	4
1.1 Монгол болон Зүүн Сибирийн томоохон нуур, усан сангийн агаар мандлын бэсрэг хэмжээсийн процесст үзүүлэх нөлөө, тоон загварчлалын аргаар судалсан байдал	4
II Бүлэг Байгаль нуурын зуны хур тунадасны уур амьсгал, бэсрэг хэмжээсийн процесст үзүүлэх нөлөөллийг тоон загварчлалын аргаар судлах нь	10
2.1 Судалгааны ажлын зорилт	10
2.2 Судалгааны арга зүй	10
2.2.1 Тоон загварын тохируулга, ашигласан мэдээ.....	10
III Бүлэг Монгол орны томоохон нуурууд болон Зүүн Сибирийн Байгаль нуурын бэсрэг хэмжээний процесст үзүүлэх нөлөөллийг тоон загварчлалын аргаар судалсан үр дүнгээс	19
3.1 Зүүн Сибирийн Байгаль нуур.....	19
3.2 Монгол орны их нууруудын хотгор дахь томоохон нуурууд	31
IV Бүлэг Судалгааны үр дүнг эрдэм шинжилгээний хурал, бүтээлд хэвлүүлсэн байдал	40

I Бүлэг Сэдвийн судлагдсан байдал

1.1 Монгол болон Зүүн Сибирийн томоохон нуур, усан сангийн агаар мандлын бэсрэг хэмжээсийн процесст үзүүлэх нөлөө, тоон загварчлалын аргаар судалсан байдал

Бусад төрлийн газрын гадаргатай харьцуулахад дэлхийн гадаргын 4%-ийг эзэлдэг нуур, усан сан нь бүс болон орон нутгийн цаг агаар, уур амьсгалыг бүрдүүлэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Нуур нь нуурын гадарга болон гадаргаас дээшхи агаар мандал болон ойролцоох гадаргын агаарын температурын хэлбэлзлийг бууруулдаг, учир нь усны дулааны багтаамж нь хүрээлэн буй газар болон агаарынхаас их байдаг тул гадаргуугаас идэвхтэй ууршилт явагдсанаар дээрх агаар мандалд усны уурын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой. Нуур болон түүний эргэн тойрон дахь дулаан, чийгшлийн ялгаатай байдлаас шалтгаалан нуур нь түүний эргэн тойрон дахь цаг агаар, уур амьсгалыг өөрчилдөг.

Хэдийгээр дулааны болон чийгшил нь тодорхой ялгаатай боловч ажиглалтын аргаар нуурын нөлөөг судлах нь тийм ч хялбар биш юм (Scott & Huff 1996). Цаашилбал, нууруудын цаг агаар, уур амьсгал, бэсрэг хэмжээсийн процесст үзүүлэх нөлөөллийн талаархи зарим тоон судалгаагаар нуураас үүдэлтэй цаг агаар, уур амьсгалын өөрчлөлт нь улирал, нуурын газарзүйн байршил зэрэг хүчин зүйлээс хамаарч өөр өөр байдаг. Нуурын гадаргууд буух хур тунадасыг авч үзвэл, нуурын агаар мандал нь өвлийн улиралд эргэн тойрныхоо газрынхаас илүү дулаан, чийглэг байдаг тул нуурын дээгүүр конвекц идэвхжиж, нуурын салхины доод талд цас ордог. Үүнийг “lake effect snow” гэж нэрлэдэг ба дэлхийн дундад болон өндөр өргөрөгийн олон нууранд ажиглагддаг (жишээ нь, Peace & Sykes 1966; Steenburgh et al. 2000). Тоон загварчлалын судалгаагаар зуны сүүлч намрын эхээр Оросын Ладога нуурын нөлөөгөөр хур тунадас 20-40% нэмэгддэгийг харуулжээ (Samuelsson et al. 2010). Өвлийн хугацааны хур тунадас Америкийн Их Нуурууд орчимд нуурын нөлөөгөөр 2 дахин хүртэл нэмэгддэг байна (Scott and Huff 1996). Эдгээр дурдагдсан судалгаануудаас харахад нуурын нөлөө газар бүрт хугацаанаас хамаарч харилцан адилгүй болох нь харагдаж байна.

Зуны улиралд нууруудын хур тунадасны нөлөөллийг зөвхөн ажиглалтаар тодорхойлоход харьцангуй хэцүү байдаг, учир нь өвөлтэй харьцуулахад


тодорхой үзэгдэл, физик процессуудын нарийн төвөгтэй байдаг. Тоон загваруудын тусламжтайгаар өмнөх зарим судалгаагаар зуны улиралд нуурууд дээрх хур тунадасны хэмжээ ойр орчмын нутгаас бага байгааг харуулсан байдаг (Хойд Америк дахь Их нуурууд: Notaro et al. 2013; Хятад дахь Тайху нуур: Gu et al. 2016). Эдгээр нууруудын зуны хур тунадасны бууралт нь гол төлөв нуурын гадаргын усны доод температуртай холбоотой илүү тогтворжсон уур амьсгалтай холбоотой бөгөөд энэ нь нуурын дээд үүсэх конвекцийг дарангуйлдаг. Гэсэн хэдий ч бусад судалгаанууд дээр дурдсан уур амьсгал нь тогтворшил бага байдаг Африкийн Их нуурууд (Thierry et al. 2015) зэрэг нууруудын хувьд дулаан улиралд нуур дээрх хур тунадасны хэмжээ нуурууд өөрсдөө нэмэгддэг болохыг харуулсан тоон загварын үр дүнг танилцуулсан байдаг (Verburg & Antenucci 2010). Дифференциал халаалт, ууршилт, конвекц, цацрагийн процессуудын нарийн төвөгтэй харилцан үйлчлэл нь нууруудын бэсрэг хэмжээний агаар мандлын процесст үзүүлэх нөлөөг ойлгоход төвөгтэй болгодог. Нуураас үүдэлтэй бэсрэг хэмжээний өөрчлөлтүүд хэвтээ ба босоо чиглэлд хэр зэрэг үргэлжлэх нь бас тодорхойгүй байдаг.

Ажиглалт, хэмжилтийн болон зайнаас тандан судлалын аргаар нуур, усан сангуудын агаар мандлын бэсрэг хэмжээний процесст үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход төвөгтэй, нарийн бус байдаг тул гадны орнуудын томоохон нууруудын нөлөөг тоон загварчлалын аргаар нилээн судалж байна (Kourzeneva et al. 2008; Gula and Peltier 2012; Thierry et al. 2015). Тухайлбал, Зүүн Африкт орших Танганика нуурын судалгаагаар нууцлагдмал болон ил дулааны урсгал жилд дунджаар 13%-18%-иар багассанаар нуурын дээр болон эргэн тойронд агаарын тогтворгүй төлөв байдлыг үүсгэдэг байхад Хойд Америкийн Их Нууруудад орших нуурууд зуны хугацаанд агаар мандлыг илүү тогтвортой төлөв байдалд оруулдаг байна (Verburg and Antenucci 2010). Нуурууд агаарын температурт харилцан адилгүй нөлөө үзүүлдэг. Жишээ нь, 7-р сард Канадын Great Slave болон Great Bear нуурууд ойр орчмын газар нутгаасаа 4°C-аар бага байдаг (Long et al. 2007) байхад Өмнөд Финляндын нуурууд жилийн туршид ойр орчмын температураас үргэлж дулаан байдаг байна (Samuelsson et al. 2010).

1-р зургаас харахад хиймэл дагуулын мэдээг боловсруулсан PERSIAN-CDR болон Европын Дунд хугацааны прогнозын төвийн ERA-INTERIM реанализ мэдээг Америкийн Их нуурууд, ОХУ-ын Ладога, Онега нууруудын орчмын бүс нутгаар зурж харахад нууруудын гадаргын температур нуурын эргэн тойрны


газар нутгийнхаас 2-8°C-аар бага, хур тунадас бага унадаг нь тодорхой харагдаж байна. Далай, тэнгисээс алслагдсан, өндөрлөг газарт орших Монгол орны хувьд бүсийн болон орон нутгийн уур амьсгалыг бүрэлдүүлэгч чухал системийн нэг нь нуур юм. Түүнчлэн, 1-р зургаас Байгаль нуур орчимд зуны хугацаанд хур тунадас эргэн тойрныхоосоо бага, Их нууруудын хотгорт хур тунадасны тархац мэдэгдэхүйц ялгаатай байгаа нь тодорхой харагдаж байна. Энэхүү хур тунадасны ялгаатай байдлын талаар физик тайлбар хангалттай хийгдэж байгаагүй юм. Цаг агаарын болон уур амьсгалын тоон загваруудад нуур, усан сангийн загварыг оруулснаар томхон нуур, усан сан бүхий газар нутагт газрын гадаргын температурт мэдэгдэхүйц өөрчлөлт өгдөг (Balsamo et al. 2012; Martynov et al. 2012). Сибирийн болон Монголын томоохон нууруудын агаар мандал, уур амьсгалын харилцан үйлчлэлийн талаар судалгаа, бэсрэг хэмжээний процесст үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг өргөжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Байгаль нуур нь ОХУ-ын Сибирийн зүүн өмнөд хэсэгт орших цэнгэг устай нуур бөгөөд төв нь 53.3°N, 108.0°E-т байрладаг. 25-30 сая жилийн өмнө үүссэн Байгаль нуур нь дэлхийн хамгийн том, хамгийн гүн нь 1642 м гүн нуур юм. 23600 км³ эзэлхүүнтэй, эзлэхүүн нь Хойд Америкийн Их нууруудын эзлэхүүнийг нийлүүлснээс их байна (Dabaeva et al. 2016). Ихэвчлэн хаврын сүүл хүртэл мөсөөр хучигдсан байдаг ба нуурын гадаргын температур зуны улиралд ч тийм өндөр байдаггүй, голчлон гүн, газарзүйн байршлаас шалтгаалж нуур болон ойролцоох газрын гадаргуугийн температурын ялгаатай байдал бий болдог.



Зураг 1. Хиймэл дагуулын мэдээгээр боловсруулсан хур тунадас, температурын орон зайн тархалт. Америкийн Их нуурууд (дээд хэсэг) болон ОХУ-ын Ладога, Онега нуурууд (дунд хэсэг). Монгол, Байгаль нуур орчмын хур тунадас, температурын орон зайн тархалт (доод хэсэг)

Байгаль нуур болон ойр орчмын бүсийн хур тунадасны тархалтын шинж чанарыг ойлгохын тулд өндөр нягтралтай хур тунадасны мэдээллийг өгдөг хиймэл нейроны сүлжээ-Уур амьсгалын мэдээллийн сан (PERSIANN-CDR, Hsu et al. 1997) ашиглан зайнаас тандан судлалын мэдээллээс хур тунадасны тооцооллыг гарган авч болно. PERSIANN-CDR хур тунадасны мэдээлэл 60°S-60°N өргөргийн зурвасыг хамрах ба Байгаль нуур болон ойр орчмын бүсийн хур тунадасны өндөр нарийвчлалтай өөр мэдээлэл байхгүй тул энэхүү судалгаанд ашигласан болно. 2005-2019 оны 15 жилийн хугацаанд PERSIANN-CDR мэдээллийн багцад хийсэн дүн шинжилгээ нь Байгаль нуурын зундаа орох хур тунадасны хэмжээ ойр орчмын газар нутгийнхаас бага, харин нуурын хойд хэсэгт энэ бууралт илүү тод ажиглагдаж байгааг харуулж байна (Зураг 2а). Гэсэн хэдий ч нуурын мандал дээрх хур тунадасны хэмжээ буурсан нь зөвхөн нууртай холбоотой эсэхийг үнэлэхэд хэцүү байдаг, учир нь ийм бууралт нь хүрээлэн буй уулстай харьцуулахад харьцангуй нам дор газар зэрэг газарзүйн шинж чанараас шалтгаалж болно.



Зураг 2. 2005-2019 оны 6, 7, 8-р саруудын дундаж (а) PERSIANN-CDR хур тунадасны тооцоолол ба (б) тоон загварын симуляци (LAKE)-аас авсан гадаргын хур тунадасны хэмжээ

Дэлхийн агаар мандал сүүлийн 100 гаруй жилийн хугацааны аж үйлдвэрийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор огцом дулаарч байгаа ба энэ уур амьсгалын өөрчлөлт нь өндөрлөг, далайн эргээс хол, хуурай газарт мэдэгдэхүйц ажиглагдаж байна. Газар болон усны гадаргын температурын өөрчлөлт нь нуурын усны стратификаци, цаашлаад биологийн процесс,

экосистемд нөлөөлдөг. Уур амьсгалын одоо болон ирээдүйн төлөв, өөрчлөлт нуур, түүний орчинд хэрхэн нөлөөлөх, эргээд энэ өөрчлөлт уур амьсгалд ямар нөлөөтэй болохыг судлах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү судалгааны ажлаар Сибирь болон Монголын томоохон нуурууд болох Байгаль, Их нууруудын хотгорт байрлах нууруудын бэсрэг хэмжээсийн агаар мандалд үзүүлэх нөлөөг тоон загварчлалын аргаар судлах үндсэн зорилт тавив.

II Бүлэг Байгаль нуурын зуны хур тунадасны уур амьсгал, бэсрэг хэмжээсийн процесст үзүүлэх нөлөөллийг тоон загварчлалын аргаар судлах нь

2.1 Судалгааны ажлын зорилт

Хамтарсан төслийн хүрээнд дараахь зорилтуудын дагуу судалгааны ажил гүйцэтгэнэ. Үүнд:

- Монгол орны Их нууруудын хотгор, Сибирийн нууруудын төлөөлөл болсон Байгаль нуур орчмын бүсээр нуур-агаар мандлын термогидродинамик параметризацийг агуулсан агаар мандлын тоон загварыг тохируулах, мужийн оновчтой сонголт, физик схемүүдийг тохируулах, сонгох.
- Нуур-агаар мандлын термогидродинамик параметризацийг агуулсан агаар мандлын тоон загварыг Байгаль болон Монгол орны томоохон нуурууд дээр хамгийн их хур тунадас ордог зуны хугацаагаар ажиллуулан, үр дүнд анализ хийх.
- Сибирь болон Монголын томоохон нууруудын агаар мандлын хязгаарын үе давхарга, бэсрэг хэмжээсийн процесс, зуны хугацааны хур тунадаст үзүүлэх нөлөөг судална. Нууруудын агаар мандал, цаг агаарын элементүүдэд үзүүлэх нөлөөний талаар физик тайлбарыг хийх.
- Шинжлэх ухааны энэ чиглэлийн хамтарсан судалгаа хөгжихөөс гадна судалгааны ажлын үр дүнгээ олон улсын мэргэжлийн хурлуудад хэлэлцүүлж, эрдэм шинжилгээний олон улсын сэтгүүлд өгүүлэл бэлтгэж хэвлүүлнэ.

2.2 Судалгааны арга зүй

2.2.1 Тоон загварын тохируулга, ашигласан мэдээ


Энэхүү судалгаанд WRF загварын 4.2.1 хувилбарыг (Skamarock et al. 2019) ашигласан. Агаар мандлын судалгаа, цаг агаарын тоон прогнозад хэрэглэгддэг WRF загвар нь цаг агаарыг урьдчилан тооцоолоход өргөн хэрэглэгддэг бөгөөд агаар мандлын судалгаанд нэн тохиромжтой загвар юм. Түүнчлэн гадаргын өөрчлөлтийн агаар мандалд үзүүлэх нөлөөг судлахад өргөн хэрэглэгддэг загвар учраас тус судалгааны ажилд сонгов.

(а) Тоон загвар. Загварын өгөгдөл, тооцоолол хэвтээ болон босоо координатын гридийн цэгүүд дээр хийгддэг. Загварын босоо координат нь даралтаас хамаарах ба газрын гадаргаас эхэлсэн доод түвшиндээ газрын гадаргын хотгор гүдгэрийг дагах бөгөөд дээшлэх тусам хавтгай гадаргуу үүсэх онцлогтой эта-координат ашигладаг (томъёо 2.1, зураг 3).


$$\eta = (p_h - p_{ht}) / (p_{hs} - p_{ht}) \quad (2.1)$$

энд: p_{hs} , p_{ht} нь харгалзан загварын газар болоод хамгийн дээд түвшний даралтын утга бөгөөд p_h – гидростатик даралт. η -гийн утга 0-ээс 1 утгатай байна. Загварын хэвтээ координат адил алхамтай гридүүдээс тогтох бөгөөд хувьсагчаас шалтгаалж бүтэн гридийн болон хагас гридийн цэгүүд дээр тооцоолол хийгддэг (зураг 4). WRF загварын үндсэн тэгшитгэлийн систем дараахь хэлбэртэй.

$$\begin{aligned} \partial_t U + (\nabla \cdot \mathbf{V}u) - \partial_x(p\phi_\eta) + \partial_\eta(p\phi_x) &= F_U \\ \partial_t V + (\nabla \cdot \mathbf{V}v) - \partial_y(p\phi_\eta) + \partial_\eta(p\phi_y) &= F_V \\ \partial_t W + (\nabla \cdot \mathbf{V}w) - g(\partial_\eta p - \mu) &= F_W \\ \partial_t \Theta + (\nabla \cdot \mathbf{V}\theta) &= F_\Theta \\ \partial_t \mu + (\nabla \cdot \mathbf{V}) &= 0 \\ \partial_t \phi + \mu^{-1}[(\mathbf{V} \cdot \nabla \phi) - gW] &= 0 \end{aligned} \quad (2.2)$$



Зураг 3. WRF загварын босоо координат



Зураг 4. WRF загварын хэвтээ координатийн гридийн цэгүүд

Тэгшитгэлүүдийн баруун гар талд forcing term гэж нэрлэгдэх загварын физик хэсэг байх ба турбулент холигдол, сферийн проекц, дэлхийн эргэлт зэргийг авч үзнэ.


(b) Загварын тохиргоо. WRF загвар бүс нутгаас хамааран Монгол орныг бүрэн хамарсан, хэвтээ чиглэлд 3 км хүртэлх алхмын нарийвчлалтай, 42 босоо түвшнээр тооцоолсон ба туршилтын аргачлалыг доорх схемээр үзүүлэв (Зураг 5). Загварт хувилбар 4.5-аас эхлэн зарим өөрчлөлт (Gu et al., 2015) хийгдсэн ба нуурын загварыг ашиглах боломжтой болсон. Нуурын загвар нь нуурын усны 1 хэмжээст баганыг 10 давхаргад хуваадаг бөгөөд босоо түвшнүүдийн зай гүнээс хамааран экспоненциалаар нэмэгддэг.

6-р зурагт сонгон авсан тооцооллын мужууд болон бүс нутгийн газар бүрхэвчийн ангиллыг харуулав. Байгаль нуураас хойшхи газар нутаг урд хэсгийн газар нутгаа бодвол нам дор ба бут, мөнх ногоон шилмүүст ойгоор голдуу бүрхэгдсэн. WRF загвар нь физик процессуудын олон төрлийн схемүүдийн сонголттой ба төслийн төлөвлөгөөнд тусгагдсан ёсоор урьдчилсан олон тоон туршилт хийсний дараа агаар мандал болон газрын гадарга орчмын физик процессуудын параметризацийн схемүүдийг дараахь байдлаар сонгож тохируулав (Хүснэгт 1). Үүнд: хязгаарын үе давхаргын YSU (Hong et al. 2006), газрын гадаргын Noah (Tewari et al. 2004), кумюлюс үүлний Grell (Grell and Freitas, 2014), богино долгионы Goddard (Chou, 1999), урт долгионы RRTM (Mlawer et al. 1997) зэрэг. Загвар ажиллуулахад шаардлагатай захын болон анхдагч нөхцөлөөр 6 цаг тутмын, 1 градусын орон зайн нарийвчлалтай NCEP FNL реанализийн (Kalnay et al. 1996) мэдээг ашиглав. Байгаль нуурын мужийн симуляцийн тооцооллыг 2005-2019 оны 15 жилийн хугацааны зуны улирлаар (6, 7, 8-р саруудаар) гүйцэтгэсэн ба загварын бодолтыг зүгшрүүлэх шаардлагын улмаас жил бүрийн тооцоолол эхлүүлэх сараас долоо хоногийн хугацаанд нэмэлт бодолтыг явуулав. Бодолтын үр дүнгийн гаралтыг цаг тутмаар гаргав.


Хүснэгт 1 Судалгаанд ашигласан WRF загварын физик процессийн параметризаацийн сонголт

Physical process	Parameterization	Reference
Микрофизик	WRF single-moment 6-class (WSM6) scheme	Hong & Lim, 2006
Хязгаарын үе давхарга	Yonsei University (YSU) scheme	Hong et al., 2006
Радиац	Rapid Radiative Transfer Model GCM application (RRTMG)	Mlawer et al., 1997
Газрын гадарга	Noah land surface model	Tewari et al., 2004
Газар бүрхэвч	Revised MM5 scheme	Jiménez et al., 2012
Гридээс бага хэмжээст конвекц	Kain–Fritsch scheme	Kain, 2004

WRF Modeling System Flow Chart



Зураг 5. Мезомасштабын WRF загварын ажиллагааны схем



Зураг 6. Байгаль нуурыг багтаасан тооцооллын бүс нутаг болон газар бүрхэвчийн ангилал


(с) Загварын тооцооллын муж. Байгаль нуур орчмын уулзүй болон газар бүрхэвчийн төрлийг 6-р зурагт харуулав. Байгаль нуур зүүн хойд талаараа Хянганы уулс, баруун өмнө хэсгээрээ Соёны уулстай залгаа оршдог. Нуурын баруун захаас эхлэн Сибирийн нам дор газар үргэлжилнэ. Тооцооллын үүрлэсэн хэлбэртэй хоёр мужийн хэвтээ гридийн нарийвчлал 15 ба 5 км болно. Мужуудын хэмжээ нь гадна мужийн хувьд 3000 км × 3000 км, дотоод мужийн хувьд 1545 км × 1050 км байна. Загварын дээд хэсэг нь 10 гПа, босоо давхаргын тоо нь 45. Тооцооллын 2-р муж Байгаль нуурыг бүхэлд нь хамарсан ба баруун талдаа Хөвсгөлийн уулсыг ахиухан багтаасан нь тоон загвараар тооцоолол хийхэд захын нөхцөлтэй холбоотойгоор тооцооллын алдаанаас сэрэмжилсэн болно. Мөн адил шалтгаанаас гадна талын тооцооллын мужид хол оршин усан гадарга аль болох бага оруулахаар тохируулсан. 6-р зурагт Байгаль нуур орчмын уулзүй болон гүний зургуудыг харуулав. Байгаль нуур зүүн хойноос баруун өмнө сунаж тогтсон, хамгийн урт хэсгээрээ 636 км, өргөөшөө 79 км хүрнэ. Дундаж гүн 744.4 м, хамгийн гүн хэсэгтээ 1642 м хүрдэг. Байгаль нуур нь дэлхийн хамгийн гүн нуур юм. Гадаргын талбай 31722 км², гадаргын өндөршил далайн төвшнөөс дээш 455 м, нуурын ёроол 1186.5 м болно.

III Бүлэг Монгол орны томоохон нуурууд болон Зүүн Сибирийн Байгаль нуурын бэсрэг хэмжээний процесст үзүүлэх нөлөөллийг тоон загварчлалын аргаар судалсан үр дүнгээс


3.1 Зүүн Сибирийн Байгаль нуур

Загварын симуляцийн үр дүнг баталгаажуулахын тулд суурь симуляци болох LAKE симуляцийн үр дүнг хэд хэдэн төрлийн ажиглалттын утгатай харьцуулсан болно. Нэгдүгээрт, зуны улирлын хиймэл дагуулын мэдээллийг боловсруулж гаргасан гадаргын хур тунадасны хэмжээ нь загварын үр дүнд гарсан Байгаль нуурын зуны хур тунадасны шинж чанартай зохих ёсоор адил байгааг харуулж байна (Зураг 2). LAKE симуляцийн хур тунадасны хэмжээ нь PERSIANN-CDR хур тунадасны тооцоололтой бараг ижил масштабтай бөгөөд загвар нь орон зайн илүү нарийвчлалтай (5 км) байдаг тул загварчлалын орон зайн тархалт хур тунадасны тооцоололтой төстэй байна. Симуляцийн үр дүнг харахад нуурын дээгүүр хур тунадасны хэмжээ ойр орчмынхоос бага байгаа бөгөөд энэ бага хэмжээтэй хур тунадас нуурын хойд хэсэгт илүү тод ажиглагдаж байгаа нь хиймэл дагуулын мэдээний үр дүнтэй нийцэж байна. Нуурын хур тунадасны дундаж хэмжээ нь 1.37 мм/өдөр бөгөөд энэ нь нуурын баруун болон зүүн хойд хэсгийн уулархаг бүсүүдийн гуравны нэг орчим юм. NOLAKE симуляци нь нуурын эх газрын эргэн тойрон дахь хур тунадасны хурдыг мөн харуулж байгааг тэмдэглэж байна (зураг дээр харуулаагүй), энэ нь нуур байгаа эсэхээс бусад хүчин зүйлүүд, тухайлбал газрын гадаргын тогтоц зэрэг хүчин зүйлүүд ч мөн адил нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна.

Гадаргуугийн хур тунадасны хэмжээнээс гадна нуурын гадаргын усны температур (LSWT) болон даралт, температур, усны уурын хольцын харьцаа, эквивалент потенциал температурын (EPT) босоо тархалтын цаг хугацааны цувааг ажиглалттай харьцуулсан болно (Зураг 7, 8). Загварын үр дүнгээс харахад загвар нь зуны эхэн үед LSWT-ийг хэтрүүлэн үнэлэх хандлагатай байгаагийн учир нь нуур 5-р сарын сүүлээр ч гэсэн ерөнхийдөө мөсөөр хучигдсан байдагтай холбоотойгоор тайлбарлаж болно. Энэ ялгаанаас бусад тохиолдолд симуляцийн үр дүн ажиглагдсан шинж чанаруудтай хангалттай хэмжээгээр төстэй байна.




Зураг 7. Загварчлал (тасралтгүй шугам) болон ажиглалт (тасархай шугам)-ын 2005-2011 оны 6, 7, 8-р саруудын нуурын гадаргын усны дундаж температурын хугацааны цуваа. Ажиглалтын мэдээг 2012 оны 3-р сар хүртэлх Along-Track Scanning Radiometer (ATSR) Reprocessing for Climate: Lake Surface Water Temperature and Ice Cover (ARC-Lake) төслийн v3 (Merchant and MacCallum, 2018) дахин босгосон реанализийн сканнерийн радиометрээс (ATSR) авсан болно




Зураг 8. Байгаль нуурын зүүн эргийн зэргэлдээх цэг дэх (Уст-Баргүзин, 53.41° , 109.01°) 2005, 2011, 2012, 2013, 2014, 2015, 2016, 2018, 2019 онуудын 6, 7, 8-р саруудын загварын симуляци (шүлүүн шугам) болон ажиглалтын (тасархай шугам) дундаж (a) даралт, (b) температур, (c) усны уур холилдох харьцаа, (d) эквивалент потенциал температурын босоо профиль. Босоо координат нь газрын түвшнээс дээш (AGL); нуурын гадаргуу дээрх өндөр нь тэг байна. Хэт олон дутуу ажиглалттай жилүүдийг дунджаас хассан болно

Нуурын мандал дээрх хур тунадасны бууралтад Байгаль нуур ямар хэмжээгээр нөлөөтэй байгааг LAKE болон NOLAKE симуляцийн үр дүнгийн хур тунадасны харьцуулалтаас харж болно (Зураг 9). Нуурын мандлын талбай дээрх хур тунадасны дундаж хэмжээ LAKE симуляцид NOLAKE симуляцийнхаас 13%-иар (0.21 мм/өдөр) бага байгаа нь зуны улиралд жилийн дундаж хур тунадасны хэмжээ 19 мм-тэй тэнцүү байна (Зураг 2а). LAKE, NOLAKE симуляцийн үр дүнг харьцуулахад зуны улиралд орох хур тунадасны хэмжээ 2005, 2010 онуудаас бусад онуудад LAKE симуляцид буурсныг харж байна (Зураг 10). Нуурын нөлөөгөөр хур тунадасны өөрчлөлт зөвхөн нуурын мандлаар хязгаарлагдахгүй, харин бүх бүс нутагт тархсан байна. Нуурын зүүн хэсэг болон зарим газарт хур тунадас NOLAKE симуляциас LAKE симуляцид илүү их байна. Эдгээр хэсгүүдэд яагаад хур тунадасны хэмжээ ихэссэнийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.


Нуурын нөлөөгөөр босоо чиглэлд үүссэн өөрчлөлтийг шинжлэв (Зураг 11). LAKE симуляцид нуурын гадарга болон босоо чиглэлд температур бага байх бөгөөд нуурын хөргөлтийн нөлөө $z \sim 2$ км хүртэл үргэлжилдэг. Усны уурын хольцооны харьцаа нь NOLAKE симуляцийг бодвол LAKE симуляцид мөн бага байна (Зураг 9с) ба ялгаа нь $z \sim 3$ км хүртэл харагдаж байна. LAKE симуляцийн энэхүү хуурай байдал нь нуурын мандал дээрх конвекцийг дарах ба усны уурын дээш тээвэрлэлтийг бууруулж, усны уур буюу ууршилтыг нуурын гадаргуугаас дээрх агаар мандалд үр дүнтэй нийлүүлдэггүй болохыг харуулж байна.



Зураг 9. LAKE болон NOLAKE симуляцийн (a) гадаргын хур тунадасны, (b) 2 метрийн агаарын температур, (c) 2 метрийн усны уурын хольцооны харьцаа, (d) гадаргын даралт, (e) хязгаарын үе давхаргын (PBL) өндөр, (f) дивергенцийн зөрөө (LAKE – NOLAKE)



Зураг 10. LAKE (тасралтгүй шугам) болон NOLAKE (тасархай шугам) симуляцийн жил бүрийн зуны (6, 7, 8-р сар) улирлын Байгаль нуурын талбайн дундаж хур тунадасны хэмжээ



Зураг 11. LAKE болон NOLAKE симуляцийн Байгаль нуурын талбай дээрх (a) температур, (b) усны уур холилтын харьцаа, (c) EPT, (d) усны уурын тээвэрлэлтийн хэвтээ дивергенцийн босоо профиль. Улаан шугам нь LAKE болон NOLAKE симуляцийн зөрүү утга. Босоо координат нь газрын түвшнээс дээш (AGL); нуурын гадаргуу дээрх өндөр нь тэг байна (Хэт олон дутуу ажиглалттай жилүүдийг дунджаас хассан болно).


Нууран дээрх хур тунадасны хэмжээг Байгаль нуур ямар хэмжээгээр хариуцаж байгааг НУУР болон NOLAKE-ийн загварчлалын хур тунадасны харьцуулалтаас харж болно. Нуурын талбай дээрх дундаж хур тунадасны хэмжээ NOLAKE симуляцийнхаас 13%-иар (0.21 мм $d-1$) бага байгаа нь зуны улиралд жилийн дундаж хур тунадасны хэмжээ 19 мм-тэй тэнцүү байна (Зураг 2а). Зуны улиралд орох хур тунадасны хэмжээ буурсныг 2005, 2010 онуудаас бусад бүх загварчлалын хувьд жил хоорондын хэлбэлзэлтэй байсан ч харж байна (Зураг S4). Нуурын нөлөөгөөр хур тунадасны өөрчлөлт зөвхөн нуурын нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй, харин бүх бүс нутагт тархсан байна. Нуурын зүүн хэсэг гэх мэт зарим газарт хур тунадас NOLAKE симуляциас LAKE симуляцид илүү их байдаг. Нуур яагаад эдгээр газруудад хур тунадасны хэмжээг ихэсгэдэг вэ гэдгийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

Зураг 11d-д усны уурын тээвэрлэлтийн хэвтээ босоо профайлыг харуулав. $\nabla h \cdot (uqv)$, энд ∇h нь хэвтээ del оператор, u нь салхины хэвтээ байгуулагч, qv нь усны уурын хольцооны харьцаа юм. Хоёр симуляцийн хувьд усны уур нь доод давхаргад ($z < 0.7$ км) нэгдэж, дээд давхаргад ($0.7 \text{ км} < z < 3.5 \text{ км}$) хуваагддаг бөгөөд энэ нь сав газрын топографийн ердийн шинж чанарыг илэрхийлдэг (жишээ нь, Satyamurty et al. 2013). Энэ нь NOLAKE симуляцид бас харагддаг тул энэ онцлог нь хоёр симуляцийн газарзүйн нийтлэг онцлогоос үүдэлтэй гэж үздэг. NOLAKE симуляцитай харьцуулахад доод давхарга дахь конвергенц ба дээд давхаргын ялгаа хоёулаа LAKE симуляцид сул байгаа нь нуур дээрх конвекц суларч байгааг харуулж байна. Түүнчлэн, нэгдэх давхарга дахь усны уурын тээвэрлэлтийн конвергенц нь NOLAKE загварчлалаас LAKE загварчлалд 20%-иар бага байна. Энэхүү сул байдал нь агаар мандлын доод хэсэгт байгаа конвектив энергийг багасгаж, улмаар конвекцийг улам сулруулж болзошгүй юм. Дээд давхарга дахь усны уурын тээвэрлэлтийн ялгаа буурах нь доод давхарга дахь усны уурын тээвэрлэлтийн конвергенцийн бууралтаас их байгаа нь багана дахь усны уурын хольцооны харьцааны хажуугийн урсгал нэмэгдэж байгааг харуулж байна.

Мэдрэг дулааны урсгал (sensible heat flux)-ын өдрийн өөрчлөлт нь LAKE симуляцид өдрийн турш мэдрэг дулааны урсгал нь доошоо (өөрөөр хэлбэл, агаар мандлаас гадаргуу руу) байгааг харуулж байна (Зураг 12а). LAKE симуляцид гадаргуугийн ойролцоох агаар мандал нь тогтвортой байдаг тул

нуурын дээгүүр конвекцийг бууруулах магадлал өндөр байдаг. Харин NOLAKE симуляцид мэдрэг дулааны урсгалын чиглэл нь өдрийн цагаар дээшээ (гадаргаас агаар мандал руу), шөнийн цагаар доошоо чиглэдэг. Нуур нь ууршилтыг нэмэгдүүлж улмаар дулааны далд урсгалыг нэмэгдүүлнэ гэсэн хүлээлтээс ялгаатай нь LAKE симуляцид ялангуяа өдрийн цагаар далд дулааны урсгал бага байдаг (Зураг 12b). LAKE симуляцийн дулааны далд урсгал (latent heat flux) бага байх үндэслэлтэй шалтгаан нь LAKE симуляцид конвекц харьцангуй сул байх бөгөөд энэ нь гадаргуугийн ойролцоо дээш чиглэсэн хөдөлгөөнийг сулруулдаг болно.


Хоёр симуляцид гадаргын хур тунадасны хоногийн өөрчлөлт нь өглөөний цагаар буурч, үд дундын үед хамгийн багадаа хүрч, улмаар хэсэг хугацаанд нэмэгддэг нийтлэг шинж чанарыг харуулж байна (Зураг 12c). NOLAKE симуляцид гадаргын хур тунадасны хэмжээ үдээс хойш мэдэгдэхүйц нэмэгдэж, 15 цагаас шөнө дунд хүртэл өндөр хэвээр байна. Нуурын нөлөөгөөр гадаргын хур тунадасны хэмжээ багасах нь үдээс хойш болон шөнөдөө илүү байгаа нь харагдаж байна. NOLAKE симуляцаас ялгаатай нь LAKE симуляцид хур тунадасны хоногийн дээд хэмжээ үдээс хойш ажиглагдахгүй байна. Байгаль нуур оршдог дунд болон өндөр өргөрөгт том масштабын меридиональ температурын градиенттай холбоотой экстратропик циклонууд хур тунадаст ихээхэн нөлөөлдөг нь мэдэгдэж байгаа боловч Байгаль нуур нь бэсрэг хэмжээндээ хур тунадасны хэмжээг бууруулж, орон нутгийн агаар мандлын термодинамик ба динамик төлөвийг өөрчилж хур тунадасны хэмжээг бууруулдаг нь харагдаж байна.



Зургаг 12. Байгаль нуурын талбайн гадарга дээрх доош чиглэсэн богино долгионы цацрагийг LAKE (тасралтгүй шугам) болон NOLAKE (тасархай шугам) симуляцид дунджаар авсан (a) гадаргуугийн мэдрэг дулааны урсгал, (b) гадаргын дулааны далд урсгал, (c) гадаргын хур тунадасны хэмжээ, (d) нийт (шингэн болон мөс) үүлний ус, (e) тунадасжих ус (босоо баганаар нэгтгэсэн усны уурын хэмжээ)-ны хоногийн хугацааны явц. (f) дахь улаан цул шугам нь LAKE болон NOLAKE симуляцийн (LAKE–NOLAKE) хоорондын ялгаа

Тунадасны бүх хэлбэрийн холимгийн харьцааны босоо профайлаас харахад LAKE болон NOLAKE симуляцийн аль алинд нь цасны хольцын харьцаа их байгаа нь харагдаж байна (Зураг 13). Нуур байгаа нь атмосферийн доод давхарга дахь үүлний уснаас бусад төрлүүдийн хольцооны харьцааг ерөнхийд нь бууруулахад хүргэдэг. Цас хольцооны харьцаа болон graupel-ын хольцооны харьцаа хоёулаа нуурын нөлөөгөөр багасах нь ойролцоогоор ижил хэмжээтэй байгаа нь хайлалтыг бууруулснаар LAKE симуляцийн гадаргуугийн хур тунадасны хэмжээг бууруулахад хүргэж байна.

Дээр дурдсан нуураас үүдэлтэй өөрчлөлтүүд, тухайлбал, гадарга орчмын хөрөлт, суларсан конвекц, усны уурын хольцооны харьцаа, хур тунадас багассан зэрэг нь харилцан уялдаатай бөгөөд нарны цацрагийн хэмжээ эдгээр өөрчлөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Нуурын гадаргын ойролцоох хөрөлтөөс үүссэн суларсан конвекц нь Зураг 12d-д үзүүлсэн шиг усны нийт агууламжийг (өөрөөр хэлбэл шингэн ба мөсөн агууламжийн нийлбэр) багасахад хүргэдэг. Үүлний нийт усны хэмжээ бага байгаа нь LAKE симуляцийн хур тунадасны хэмжээ бага байгаатай шууд холбоотой. Үүлний оптик зузааныг бууруулдаг нийт өтгөрүүлсэн үүлний усны агууламж болон тунадасжих усны аль алиных нь бууралт нь Зураг 12f-д үзүүлсэн шиг доошоо чиглэсэн богино долгионы цацрагийг илүү хүчтэй болгодог. LAKE симуляцийн хоногийн хугацааны доош чиглэсэн богино долгионы цацраг NOLAKE симуляцийнхаас 6.2 Вт/м^2 -ээр их байна. Нуурын нөлөөгөөр суларсан конвекцийн улмаас нуурын мандал дээрх босоо баганы усны уур, конденсацгийн хэмжээ өөрчлөгдөх нь гадаргад ирж буй богино долгионт цацрагийг нэмэгдүүлж нуурын гадаргууг дулаарахад хүргэдэг бөгөөд энэ нь конвекцийн сулралтыг хэсэгчлэн нөхөж чаддаг.




Зураг 13. Байгал нуурын талбайн дунджаар авсан үүлний ус (cloud water), борооны ус (rainwater), мөсөн талст (ice crystal), цас (snow), graupel-ын хольцооны харьцааны (a) LAKE болон (б) NOLAKE симуляци болон (в) LAKE болон NOLAKE симуляци дахь босоо профиль. Босоо координат нь газрын түвшнээс дээш (AGL); нуурын гадаргуу дээрх өндөр нь тэг байна.

3.2 Монгол орны их нууруудын хотгор дахь томоохон нуурууд

Энэ хэсэгт 2.2.1-т дурдсан аргачлалаар Монголын Их Нууруудын хотгорт орших томоохон нууруудын агаар мандалд үзүүлэх нөлөөг тоон загварчлалын аргаар судлав. Монгол орны төв болон баруун хэсгийг оруулсан 3 бүс нутгийг тохируулж хамгийн дотор талын буюу нарийвчлал өндөртэй бүс нутгийг багтаав.


Симуляцийн үр дүнг бататгахын тулд Европын дунд хугацааны прогнозын төвийн $0.75^{\circ} \times 0.75^{\circ}$ нарийвчлалтай ERA-INTERIM реанализ мэдээтэй харьцуулав. 15-р зурагт бодолтын хугацааны 2-р бүс нутгийн газрын гадарга дахь даралт, 2-метрийн төвшний температурыг харьцуулан харуулав. Бүс нутгийн даралт болон температурын тархалтыг харвал уулзүйг дагаж хотгор газар температур их, уулархаг газраар температур бага байх нь харагдаж байна. Реанализ мэдээ болон загварын үр дүнгүүд өөр өөр нарийвчлалтайн улмаас зарим зөрүүтэй байдал харагдах ч орон зайн тархалт ерөнхийдөө адил байна. Эндээс харахад орон зайн нарийвчлал хэдий чинээ сайн байх тусам төдий чинээ нарийвчилсан үр дүн харагдах нь тодорхой байна.




Зураг 14. (a) Тооцооллын бүс нутгийн өндөршил болон (b) 3-р домэйны газар ашиглалт, газрын бүрхэвч. (Цагаан өнгө – нуур)

Монголын Их нууруудын хотгорын Увс, Хар-Ус, Хар, Үүрэг, Дөргөн зэрэг 300 орчим нуурыг багтаасан газрыг хамарна (Зураг 14). 2015 оны зуны улирлаар симуляц явуулж Монголын Их Нуурууд дахь нуурууд цаг агаарын элементүүдэд ямар нөлөө үзүүлэх талаар тооцоолол хийв. Симуляцийн анхдагч болон захын нөхцлөөр АНУ-ын Агаар мандлын үндэсний төвийн 6 цаг тутмын мэдээг ашиглав.


16-р зурагт LAKE, NOLAKE симуляцуудын ил дулааны урсгал, 2-метрийн төвшний агаарын температур, хязгаарын үе давхаргын өндрийн хоногийн явцыг харуулав. Шөнийн хугацаанд LAKE, NOLAKE симуляцуудын ил дулааны урсгал ойролцоо байх ба өдрийн хугацаанд NOLAKE симуляцийн утга нэмэгдэж, харин LAKE симуляцийнх сөрөг утгатай хэвээр байгаа нь агаараас нуурын мандал дулаан авч байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл ил дулааны урсгал бага байгаагийн улмаас нуурын гадаргын температур нуурын мандал дээрх агаарынхаас бага, хязгаарын үе давхаргын өндөр бага байна. Энэ нь нуурын нөлөөгөөр агаар мандал нуурын гадаргын харилцан үйлчлэл ургамлан бүрхэвч ба агаар мандал хоорондынхоос сул, нуурын дээд хэсгийн агаар илүү тогтвортой байна гэсэн үг. Энэ үр дүн Байгаль нуурын симуляцийн үр дүнтэй таарч байна. LAKE, NOLAKE симуляцуудын агаарын температурын максимум ажиглагдах хугацаа өөр өөр байна. LAKE симуляцид 2-метрийн агаарын температур 18-19 цагт 15.2°C хүрч буй бол NOLAKE симуляцийн максимум 2 цагаар эрт, 26.7°C хүрч байна. LAKE симуляцийн максимум ажиглагдах хугацаа хожуу байгаа нь усны дулаан багтаамж агаарынхаас их байдагтай холбоотой. NOLAKE симуляцид температурын өсөлт хурдан байхад нуурын гадарга хөрөхдөө удаан байна. Харин температурын хоногийн амплитуд NOLAKE симуляцийнхад их байна. Температурын хамгийн их зөрөө үдээс хойш ажиглагдаж, цаашид аажим буурсаар үүрээр 5 цаг орчимд хамгийн бага зөрөөтэй болж байна.



Зураг 15. ERA-INTERIM реанализ болон симуляцийн газрын гадарга дахь даралт, 2-метрийн төвшний агаарын температур




Зураг 16. LAKE, NOLAKE симуляцуудын ил дулааны урсгал, 2-метрийн төвшний агаарын температур, хязгаарын үе давхаргын өндрийн хоногийн явц



Зураг 17. LAKE, NOLAKE симуляцуудын ил дулааны урсгал, 2-метрийн агаарын температур, хязгаарын үе давхаргын сарын хугацааны цуваа

17-р зурагт LAKE, NOLAKE симуляцуудын ил дулааны урсгал, 2-метрийн агаарын температур, хязгаарын үе давхаргын долдугаар сарын хугацааны цувааг харуулж байна. NOLAKE симуляцид газрын гадаргаас агаар мандал руу өгөх ил дулаан өдрийн хугацаанд үргэлж их, шөнийн хугацаанд LAKE симуляцийнхтай ойролцоо байх нь харагдана. LAKE симуляцийн ил дулааны урсгал сөрөг утгатай байгаа нь нуурын мандал мандлаас дээшээ байх агаараас хүйтэн байгааг илтгэнэ. Нуурын мандлаас дээш 2-метрийн төвшний агаарын температурын хоногийн амплитуд нуургүй симуляцийнхаас бага байна. NOLAKE симуляцид хязгаарын үе давхаргын өндөр LAKE симуляцийнхаас үргэлж их, өдрийн хугацаанд заримдаа 1.8 км хүртэл өндөр байгаа нь салхины босоо байгуулагчийн хурд их, конвекцийн хөдөлгөөн ихтэй болохыг илтгэнэ. Сарын хугацаанд хоёр симуляцийн цаг агаарын элементүүдийн тренд адил байх ч амплитуд өдөр өдрөөр харилцан адилгүй харагдаж байгаа нь тухайн өдрүүдийн синоптик процесстой холбоотой ба өөр өөр газрын гадарга агаар мандалтай өөр өөрөөр харилцан үйлчлэлцэхийг илтгэж байна. Зарим сэрүүн өдрүүдэд 2 симуляцийн температурын амплитуд бага, утгууд хоорондоо дөхөж байхад зарим өдрүүдэд температурын ялгаа их, ялангуяа NOLAKE симуляцийн температурын амплитуд их байгаа нь харагдаж байна. Сарын турш LAKE симуляцийн температурын дээд утга 20°C-ээс ихгүй байхад NOLAKE симуляцийн температур 33°C хүрч байна. 2 симуляцийн температурын хамгийн их ялгаа 15.9°C хүрч байна.

18-р зурагт 2-метрийн төвшний агаарын температур, газрын гадаргаас дээш 100 метрээр дундажласан усны уурын хольц, салхи, хязгаарын үе давхаргын өндрийн LAKE, NOLAKE симуляцуудын зөрөөний орон зайн тархацыг харуулж байна. Бодолтын хугацаанд нуурын мандалд болон нуурын орчимд эргэн тойрны газар нутгаас дунджаар 8.7°C хүйтэн, нуурын мөр тодорхой харагдана. Зуны хугацаанд Их нууруудын хотгорт нууруудын улмаас эргэн тойрны орчин сэрүүсдэг нь харагдаж байна. Усны уурын хольцын зөрүү 0.9 г/кг хүрэх ба 200 км хүртэлх газар нутаг зөрүү ажиглагдаж байна. Нуур нь хязгаарын үе давхаргын өндрийг 564 метр хүртэл бууруулж, нуураас гадагш чиглэлтэй салхи буюу дивергенц хөдөлгөөнийг нөхцөлдүүлж байна. Томоохон нууруудаас гадагш чиглэлтэй салхи тод харагдаж, харин жижиг нууруудын ойролцоо температур, усны уурын хольцын зөрүү харагдаж буй ч салхины



Зураг 18. 2-метрийн төвшний агаарын температур, газрын гадаргаас дээш 100 метр баганаар дундажласан усны уурын хольц, салхи, хязгаарын үе давхаргын өндрийн LAKE, NOLAKE симуляцуудын зөрөөний орон зайн тархац.

зөрүү төдийлөн харагдахгүй байгаа нь симуляцын хэвтээ чиглэлийн гридийн алхамтай холбоотой ба тухайн жижиг нууруудыг агуулсан жижиг мужаар симуляц гүйцэтгэвэл зөрүү тод харагдах болно. Эдгээр өөрчлөлтүүд нь Америкийн Их Нууруудын агаар мандалд үзүүлэх нөлөөтэй чанарын хувьд төстэй байна (Notaro et al. 2013). Энэ ажил өгүүлэл болон хэвлэгдсэн ба симуляцийн хугацааг уртасган тооцоолол гүйцэтгэж, орон нутгийн агаарын циркуляцийг цаашид нарийвчлан судлах ажил үргэлжилж байгаа.

Тус судалгааны ажлын энэхүү хэсэгт Увс нуурын цаг уурын элементүүдэд үзүүлэх нөлөөг зуны хугацаагаар туршсан бол цаашид өвлийн хугацааны ямар нөлөө үзүүлэхийг тоон загварчлалын аргаар тооцоолох шаардлагатай. Зуны хугацаанд нуурын цаг агаарт нөлөөлөх нөлөө адилавар шинж чанартай хэдий ч өвлийн хугацаанд ойролцоо өргөрөгт орших эх газрын томоохон нууруудаас шинж чанар өөр байж болзошгүй. Тухайлбал, Америкийн Их Нуурууд өвлийн улиралд ойролцоох газар нутгаас дулаан гадаргатай байдгаас lake effect snow гэж нэрлэгдэх бэсрэг цаг агаарын үзэгдлийг бий болгодог. Түүнчлэн Их Нууруудын газар нутагт өвлийн хугацаанд томоохон газар нутгийг хамардаг Сибирийн их даралтын орны төв тогтвортой байрладаг, агаарын доод давхарга маш эрчимтэй инверсийн давхаргатай, агаар мандал маш тогтвортой байдаг онцлогтой. Иймээс томоохон хэмжээний нуурууд Сибирийн их даралтын оронд хэрхэн нөлөөлдөг талаар судлах нь сонирхолтой ажил болно.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Төслийн хүрээнд Зүүн Азийн уулархаг бүс нутгийн томоохон усан сангуудыг мезо масштабын агаар мандлын үзэгдлийн эх үүсвэр, тэр дундаа аюултай үзэгдлийн эх үүсвэр болгон авч үзэж, тоон загварчлалын аргаар туршилт хийн судлах явдал байв. Энэ зорилгоор тухайн бүс нутгуудад анх удаа ажиглалтын боломжит бүх өгөгдөл (хиймэл дагуулын мэдээлэл, ре-анализ, цаг уурын ажиглалтын мэдээлэл, мезо масштабын загварчлал)-ийг ашигласан.

WRF загварыг анх удаа нуурын мөсний горим, усны давсжилтын мөсний бүрхэвч, дулааны нөхцөлд үзүүлэх нөлөөг харгалзан үзсэн нуурын загвартай холбож, уулархаг газрын онцлог шинж чанартай Зүүн хойд Азийн бүс нутаг дах томоохон нууруудын бүсэд тохируулж ашиглав. Увс нуур дээрх нуурын конвекц, түүнтэй холбоотой мезо масштабын хуйлраа, конвектив үзэгдлийн шинжилгээ, загварчлалыг хийж гүйцэтгэв.

WRF загварын симуляцийн үр дүн нь хиймэл дагуулын зургийг ашиглан хангалттай дөхүү байгаа нь батлагдсан. Загварчлалын үр дүнд анализ хийж олон улсын хуралд хэлэлцүүлж, WoS/Scopus санд бүртгэлтэй сэтгүүлд бэлтгэж хэвлүүлсэн. Цаашид тоон загварын тухайн бүс нутагт тохируулсан тохиргоог ашиглан уулархаг газар дахь бүс нутгийн загварчлалд ашиглах, үр дүнг цаашдын гүнзгийрүүлсэн судалгаанд хэрэглэх, бүс нутгийн симуляц, агаар мандлын мезо масштабын процесс, тоон загвар зэрэг хичээлүүдэд хэрэглэх боломжтой.

Тоон загварын тухайн бүс нутагт тохируулсан тохиргоог ашиглан уулархаг газар дахь бүс нутгийн загварчлалд ашиглахыг зөвлөж байна. Энэхүү судалгаа нь нуур-агаар мандлын харилцан үйлчлэлийг тоон загварын аргаар судлах томоохон ажлын эхлэл ба цаашид бүс нутгийн мезо масштабын процессийн талаар судалгаа хийхэд дараах зөвлөмж хүргүүлж байна. Үүнд:

- Хиймэл дагуулын мэдээлэл, ре-анализ мэдээ, мезо масштабын загварчлалын үр дүнг ашиглан уулархаг газрын томоохон нууруудын мезо масштабын конвектив хуйлраа үүсэх нөхцөл, динамикийн судалгааг хийх. Хүчтэй салхи, конвектив хур тунадас үүсэх магадлалын дүн шинжилгээ, эдгээр үзэгдлийн талаархи статистик мэдээллийг бий болгох.
- Хиймэл дагуулын мэдээ, ре-анализ мэдээ, мезо масштабын загварчлалын үр дүнг ашиглан уулархаг бүс нутаг дах томоохон усан сан бүхий газрын агаарын циркуляцийг судлах: бриз салхи ба катабат урсгал, улирлын динамик, хүчтэй салхины давтамжийг судлах.
- Давсархаг нуурын дулааны горим, нуурын мөсний горимд үзүүлэх давсжилтын нөлөөлөл, түүний агаар мандалтай харилцан үйлчлэлийг судлахын тулд тус судалгаанд ашигласан мезо масштабын загварчлалыг ашиглах боломжтой.
- Хиймэл дагуулын мэдээ, ре-анализ мэдээ, мезо масштабын загварчлалын үр дүнг ашиглан хиймэл усны томоохон байгууламж бүхий бүс нутагт мезо масштабын үзэгдлийн нөхцөл, хөгжлийн динамикийг судлах. Салхины эрс тэс горим, хэт хур тунадас орох магадлалын үнэлгээг тоон загвар болон бусад арга зүй, мэдээллийг ашиглан хийх боломжтой

IV Бүлэг Судалгааны үр дүнг эрдэм шинжилгээний хурал, бүтээлд хэвлүүлсэн байдал

1. Импакт фактор $IF=4.720$ *Geophysical Research Letters* эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэхээр мэдүүлсэн.

manuscript submitted to *Geophysical Research Letters*

1

Effects of Lake Baikal on Summertime Precipitation Climatology over the Lake Surface

2

3

4

5

6

Hyunho Lee¹, Gantuya Ganbat², Han-Gyul Jin³, Jaemyeong Mango Seo⁴,
Sungju Moon³, Hyejeong Bok⁵, and Jong-Jin Baik³

7

8 ¹ Department of Atmospheric Science, Kongju National University, Gongju, South Korea

9 ² Faculty of Engineering, German-Mongolian Institute for Resources and Technology,

10 Ulaanbaatar, Mongolia

11 ³ School of Earth and Environmental Sciences, Seoul National University, Seoul, South Korea

12 ⁴ Max-Planck Institute for Meteorology, Hamburg, Germany

13 ⁵ National Air Emission Inventory and Research Center, Ministry of Environment,

14 Cheongju, South Korea

15

16 Corresponding authors: Jong-Jin Baik (jjbaik@snu.ac.kr) and Gantuya Ganbat

17 (gantuya@gmit.edu.mn)

18

19 Key Points:

20

21

22

23

24

25

26

- We conducted two 15-yr cloud-resolving simulations to investigate how Lake Baikal affects summertime surface precipitation over it
- A decrease in air temperature weakens convection over the lake, reducing precipitation by 13% as well as water vapor amount
- It is essential to consider complex interactions among clouds, radiation, and lake surfaces to characterize the lake effects

2. ОХУ-ын Эрхүү хотод 2021 оны 6 дугаар сарын 14-17-нд болсон “Климатические риски и космическая погода” олон улсын хуралд илтгэл:
Gantuuya Ganbat, Ganbat Danaa “Lake-atmosphere Interactions in the Mongolian Great Lakes and the Baikal Lake”



3. ISBN 978-5-9624-1956-5 дугаартай “Климатические риски и космическая погода” олон улсын хурлын эмхэтгэлд өгүүлэл
https://drive.google.com/file/d/1gTW8xE_Xvued_-y1A12liTyLdzrmpfMv/view



Сверкунова Т. А., Вологжина С. Ж., Латышева И. В., Лощенко К. А. Современные особенности струйных течений над районами аэродрома Иркутск	200
Синюкович В. Н., Латышева И. В., Макухин В. Л. Климатические риски дождевых паводков на притоках Южного Байкала	207
Фролов Д. М. Современные климатические риски	215
РАЗДЕЛ 4. ФИЗИКА И ДИНАМИКА АТМОСФЕРЫ. ПРОЦЕССЫ И ВЗАИМОДЕЙСТВИЕ ВЕРХНЕЙ, СРЕДНЕЙ И НИЖНЕЙ АТМОСФЕРЫ / SECTION 5. PHYSICS AND DYNAMICS OF THE ATMOSPHERE. PROCESSES AND INTERACTION OF THE UPPER, MIDDLE AND LOWER ATMOSPHERES	
Badamkhand Tserennadmid, Jambajamts Lkhamjav. A Statistical Analysis of Food Near the Buyant-Ukhaa Airport	220
Ganbold Boldbaatar, Jambajamts Lkhamjav. Numerical Simulation for Thunderstorm Cases over the Ulaanbaatar Area	228
Gantuya Ganbat, Ganbat Danaa. Lake-atmosphere Interactions in the Mongolian Great Lakes and the Baikal Lake	234
Алексеева Е. Г., Анискина О. Г. Влияние циркуляции атмосферы на экстремальную температуру воздуха на Северо-Западе России	238
Васильев М. С. Динамика высоты тропопаузы над Центральной Яку- тией по данным радиозондирования атмосферы в 2020 г.	243
Данильчук Е. И., Демьянов В. В. Оценка частоты девиации в спек- тре мерцаний фазы с помощью аналитической модели	247
Диденко К. А., Погорельцев А. И. Применение непрерывного вейвлет преобразования для изучения планетарных волн	254
Домбровская Н. С., Мордвинов В. И., Зокальцева О. С. Вертикаль- ная структура низкочастотных колебаний стратомезосферы	261
Исмагилов Н. В., Тиглева А. И., Николаев А. А. Сезонные пере- стройки циркуляции в стратосфере Северного полушария	270
Курдяева Ю. А., Кшевещкий С. П. Исследование распространения атмосферных волн от локальных тропосферных источников в верхнюю ат- мосферу с учетом фонового ветра	275
Молчанова Н.О., Полетаев А. С., Васильев Р. В., Ченский А. Г. Об- зор атмосферных эффектов, связанных с грозовыми разрядами	281
Николашкин С. В., Колтовской И. И., Парников С. Г., Титов С. В. Регистрация усиления красной эмиссии атомарного кислорода в свечении ночного неба во время запуска тяжелой ракеты с космодрома «Восточный»	287
Переведенцев Ю. П., Шерстюков Б. Г., Шанталинский К. М., Мирсаева Н. А., Аухадеев Т. Р., Мягков М. А., Парубова Е. М. Изменения температуры воздуха и атмосферных осадков на территории России в XX– XXI веках	292

Lake-Atmosphere Interactions in the Mongolian Great Lakes and the Baikal Lake

Gantuya Ganbat (gantuya@gmit.edu.mn)¹, Ganbat Danaa²

¹German-Mongolian Institute for Research and Technology, Ulaanbaatar, Mongolia

²Mongolian University of Science and Technology, Ulaanbaatar, Mongolia

Abstract/ Lakes influence the regional atmosphere through modifying thermodynamic characteristics. This study examines the effects of lakes in the Mongolian Great Lakes region and the Baikal lake on summertime meteorological parameters using the Weather Research and Forecasting (WRF) model. Diurnal variations in the lakes' impact on the atmosphere are found through changing the surface energy budget, which includes changes in sensible and latent heat fluxes. The changes in heat fluxes cause relatively lower surface temperature which leads to a shallow boundary layer over the lake surfaces. Greater heat capacity in water bodies compared to grasslands causes slower heating and cooling rates in the lakes. The amplitude of air temperature over the lake surfaces is smaller than that over the grasslands. Lakes promote diverging winds near the ground, furthermore, tend to stabilize the overlying atmosphere in the summertime.

Keywords: lake; atmosphere; interaction; Mongolian Great Lakes; numerical simulation;

Introduction

One of the important factors determining the regional climate is the presence of the lakes. Interactions between the lake and atmosphere through exchanging heat, water vapor, and momentum fluxes [1] define the regional climate and weather. Atmospheric circulations in the surrounding region are affected by lakes through differences in thermal and frictional properties between lake and land surfaces [2].

Numerous numerical studies focused on lake-atmosphere interactions. Notaro et al. [3] studied the impacts of the Laurentian Great Lakes on regional climate by conducting numerical simulations with and without lakes and presented the decreased (increased) sea-level pressure in autumn-winter (summer), weakened cold-season cyclones and increased (decreased) turbulent fluxes during the cold (warm) season due to the presence of the lakes. Thiery et al. [4] have conducted simulations using the Weather Research and Forecasting (WRF) model to investigate the effects of African Great Lakes on regional climate and revealed that the daytime cooling by lakes modifies the dynamics and stability of the regional atmospheric condition.

Satellite data shows the reduced precipitation on and surrounding lakes (e. g., Baikal lake) in the summertime (Figs. 1, 2). Dynamic interactions between lakes and atmosphere should be conducted in order to explain the importance of the lakes in atmospheric circulations through assessing the changes in meteorological parameters.

The Mongolian Great Lakes depression region is an important basin generally in semi-arid areas which includes over 300 lakes. The lake-atmosphere interactions in the Great Lakes depression region are likely to modify the atmospheric boundary layer and there is a lack of its investigation through numerical methods. This study investigates the impacts of lakes in the summertime in the Mongolian Great Lakes region on some meteorological parameters.




Fig. 1. Precipitation rate in mm/day over Mongolia and its surrounding region constructed from the ERA-Interim




Fig. 2. Precipitation rate constructed from the PERSIANN data

Data and Methods

